



**НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛЬД
2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн /цаашид НССДС гэнэ/ бакалаврын үндсэн болон цагийн хөтөлбөрт оюутан элсүүлэхэд энэхүү журмыг баримтлах бөгөөд БШУ-ны Сайдын 2024 оны А/143 тоот тушаалын 1,2 дугаар хавсралт, БШУ-ны Сайдын 2024 оны А/170 тоот тушаал, НССДС-ийн Бакалаврын сургалтын журамд нийцсэн байна.
- 1.2. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь хүний сурч боловсрох эрхийг хангасан, хүртээмжтэй, ил тод, шударга, тэгш хамруулах зарчмыг хангасан байна.
- 1.3. 2024-2025 оны хичээлийн жилд НССДС-д оюутан элсүүлэх хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, сургуулийн материаллаг бааз, багшлах бүрэлдэхүүний нөөц хангамж зэрэгт үндэслэн сургуулийн Удирдах зөвлөл тогтооно.
- 1.4. Элсэлтийн комиссыг захирлын тушаалаар байгуулан ажиллуулна.
- 1.5. Элсэлтийн журам, элсэлтийн ерөнхий шалгалт /ЭЕШ/-ын оноог тооцох болон холбогдох бусад мэдээллийг НИЙГЭМ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛЬ гэсэн фэйсбууц хуудас болон <http://usp.mn> цахим хуудсанд байрлуулна.
- 1.6. Улаанбаатар хот болон бусад аймаг, хотоос оюутан элсүүлэх ажлыг газар дээр нь биечлэн болон цахим хэлбэрээр хоёр удаа зохион байгуулна.
- 1.7. НССДС-д оюутан элсүүлэх мэргэжлийн хөтөлбөр, индекс, хяналтын тоо, суралцах хугацаа, хэлбэр, нийт судлах багц цаг, оюутан элсүүлэх нийтлэг шалгуур, босго оноо, сургалтын төлбөрийн хэмжээ зэрэг мэдээллийг сургуулийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд түгээж ажиллана.
- 1.8. Элсэгч нь энэхүү журмын хэрэгжилт, сургуулийн Элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдолоо бичгээр гаргаж болно.
- 1.9. Журмын нэр, томъёоны тайлбар, тодорхойлолт:
 - 1.9.1. "Хяналтын тоо" - элсүүлэх оюутны тоог;
 - 1.9.2. "Бүртгүүлэгч" - элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг;
 - 1.9.3. "Элсэгч" - хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг;
 - 1.9.4. "Шилдэг элсэгч" - олон улс, улс, аймаг, дүүргийн хэмжээний Нийгэм судлал, Монгол хэл, Гадаад хэл, Математик, Мэдээлэл зүйн олимпиад, урлаг, спортын зэрэг уралдаан, тэмцээнд амжилт гаргасан, нийгэм, олон нийтэд тустай сайн үйл хийсэн элсэгчийг;
 - 1.9.5. "Тэтгэлэг" - НССДС-аас нийгмийн хариуцлагын хүрээнд оюутанд олгодог тодорхой болзол бүхий сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг;
 - 1.9.6. "Элсэлтийн систем" - сургуулийн элсэлтийн цахим бүртгэлийн системийг;

- 1.9.7. "Элсэлтийн комисс" - элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- 1.9.8. "Мэргэжлийн хөтөлбөр" - Сургалтын тусгай зөвшөөрөлд заасан бакалаврын зэрэг олгох тухайн мэргэжлийн нэршил, хөтөлбөрийг;
- 1.9.9. "Үндсэн хөтөлбөр" - 4 жилийн хугацаанд өдрийн хэлбэрээр суралцуулах хөтөлбөрийг;
- 1.9.10. "Цагийн хөтөлбөр" - 2 жилийн хугацаанд эчнээ болон цахим хэлбэрээр суралцуулах хөтөлбөрийг тус тус ойлгоно.

Хоёр. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА, БОСГО ОНОО

- 2.1. Бүртгүүлэгч нь энэхүү журмыг уншиж судалсан байх үүрэгтэй.
- 2.2. НССДС-д элсэхээр бүртгүүлэгч нь бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой байна.
- 2.3. НССДС-ийн үндсэн хөтөлбөрийн өдрийн ангид элсэхийг хүсэгч нь 2023 онд ЭШ өгсөн ЭШ-ын хичээлийн төрөл, оноо нь НССДС-д элсэх шаардлага, босго оноог хангасан байна.
- 2.4. Бакалаврын хөтөлбөрт суралцах хусэлтэй иргэнийг дараах тохиолдолд элсэлтийн шалгалтын оноо шаардахгүйгээр элсуулэн суралцуулж болно.
Үүнд:
 - 2.4.1. Дэд бакалавр, бакалаврын боловсролтой иргэн;
 - 2.4.2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 медальт байрт шалгарсан иргэн тухайн чиглэлийн хөтөлбөрт;
 - 2.4.3. Гадаад болон дотоодын еренхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;
 - 2.4.4. Гадаадын аль нэг улсын дээд боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын ижил тувшийн хөтөлбөрт шилжин суралцах иргэн;
 - 2.4.5. Элсэн суралцах мэргэжлийн чиглэл/хөтөлбөр/-ээр 3-аас доошгүй жил ажиллаж нийгмийн даатгал төлсөн 30-аас дээш насны иргэн.
- 2.5. Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургууль тегсөгч олон улсын шалгалтын үнэлгээгээ элсэлтийн шалгалтын үнэлгээнд дүйцүүлэх эсвэл элсэлтийн шалгалтад хамрагдаж авсан онооныхоо аль өндөр оноогоор сургуульд элсэн орж болно.
- 2.6. НССДС-д элсэхийг хүссэн иргэн нь элсэлтийн цахим бүртгэлийн системд <http://usp.edu.mn/burtgel> хаягаар нэвтэрч бүртгүүлсэн байна.
- 2.7. Үндсэн хөтөлбөрөөр өдрийн ангид элсэгч нь ЭШ-ыг элсэлтийн шалгалт-1, элсэлтийн шалгалт-2 гэсэн хэлбэрээр нийт 4 хичээлийг БСШУ-ны Сайдын тушаалд зааснаар өгнө.
- 2.8. НССДС нь дараах шалгуур, босго оноог хангасан иргэнийг Сэтгэл судлал, Нийгмийн ажил бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулна. Үүнд:
Нийгмийн ажил бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулна.

| ҮНДСЭН ХӨТӨЛБӨР /өдрийн сургалт/ | | | | | |
|----------------------------------|---------------|--|--|-----|---------|
| № | Мэргэжил | Шалгуур /ЭЕШ-ын хичээл, босго оноо/ | | Кр | Хугацаа |
| | | Хичээл-1 | Хичээл-2 | | |
| 1 | Сэтгэл судлал | Нийгмийн ухаан, Математик Босго оноо: 480 | Монгол хэл, Англи хэл Босго оноо: 480 | 120 | 4 жил |
| 2 | Нийгмийн ажил | Хичээл -1 | Хичээл-2 | 120 | 4 жил |
| | | Нийгэм судлал, Англи хэл Босго оноо: 480 | Монгол хэл, Математик Босго оноо: 480 | | |
| | | | | | |

| ЦАГИЙН ХӨТӨЛБӨР /эчнээс, цахим сургалт/ | | | | | |
|---|---------------|------------------------------|----|---------|--|
| № | Мэргэжил | Шалгуур | Кр | Хугацаа | |
| 1 | Сэтгэл судлал | Бакалаврын дээд боловсролтой | 80 | 2 жил | |
| 2 | Нийгмийн ажил | Бакалаврын дээд боловсролтой | 80 | 2 жил | |

- 2.9. Үндсэн хөтөлбөрөөр өдрийн анgid элсэгчийн оноог тооцохдоо суурь шалгалт /хичээл-1/ өгсөн аль нэг хичээлээр 480-аас дээш оноо авсан, дагалдах шалгалт /хичээл-2/ өгсөн хичээлээр 480-өөс дээш оноо авсан бүртгүүлэгчийг тус сургуульд элсэх болзول хангасан хэмээн үзэж Элсэлтийн комисс бүртгэлийг баталгаажуулна.
- 2.10. Суурь шалгалт /хичээл-1/ өгсөн хоёр хичээл тус бүрт 480-аас дээш оноо авсан бүртгүүлэгчийг дагалдах шалгалтын /хичээл-2/ оноог харгалзахгүйгээр тус сургуульд элсэх болзол хангасан хэмээн үзэж Элсэлтийн комисс бүртгэлийг баталгаажуулна.
- 2.11. ЭЕШ өгөөгүй болон ЭЕШ өгсөн боловч НССДС-д элсүүлэх босго оноонд хүрээгүй бол элсэгчээр бүртгэхгүй.

Гурав. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, БҮРТГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 3.1 Оюутан элсүүлэх ажлыг ЭЕШ дууссан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ.
- 3.2 НССДС-д өдрийн хөтөлбөрт элсэх шалгуур, болзлыг хангасан элсэхийг хүсэгч нь дараах хэлбэрүүдээр бүртгүүлж болно. Үүнд:
- 3.2.1. 2024 оны 7-р сарын 25-ны дотор <http://usp.edu.mn/burtgel> хаягаар бүртгүүлэх;
 - 3.2.2. 2024 оны 8-р сарын 01-25-ны хооронд өөрийн биеэр ирж бүртгүүлэх.
- 3.3 НССДС-ийн өдрийн анgid элсэгч нь 2024 оны 8-р сарын 30-ны дотор сургууль дээр ирж сургалтын мэдээллийн системд бүртгүүлж, суралцагчийн гэрээ байгуулна. Дурдсан хугацаанд гэрээ байгуулаагүй элсэгчийг бүртгэлээс хасна.
- 3.4 Өдрийн анgid элсэгч нь суралцах гэрээ байгуулахдаа дараах баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна. Үүнд:
- 3.4.1. ЭЕШ-ын батламж /эх хувь/;
 - 3.4.2. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ /эх хувь/;

- 3.5. Цагийн хөтөлбөрт танхмын хэлбэрээр элсэхийг хүсэгчийг <http://usp.edu.mn/burtgel> вэб хуудас, сургуулийн фейсбуук пэйж хуудсаар 2024 оны 9-р сарын 01-20-нд /намрын улирал/, 2025 оны 2-р сарын 01-20-нд /хаврын улирал/ бүртгэнэ.
- 3.6. Цагийн хөтөлбөрт цахим /онлайн/ хэлбэрээр элсэхийг хүсэгчийг <http://usp.edu.mn/burtgel> вэб хуудас, сургуулийн фейсбуук пэйж хуудсаар 2024 оны 8-р сарын 05-20-нд /намрын улирал/, 2024 оны 1-р сарын 01-20-нд /хаврын улирал/ бүртгэнэ.
- 3.7. Цагийн хөтөлбөрөөр элсэгч нь суралцах гэрээ байгуулахдаа дараах баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна. Үүнд:
- 3.7.1. Бакалаврын дипломын хуулбар;
 - 3.7.2. Иргэний үнэмлэхний хуулбар;
 - 3.7.3. Сургалтын төлбөр төлсөн баримт.
- 3.8. Элсэлтийн бүртгэлийн хураамжийн хэмжээ 10,000 төгрөг /цагийн хөтөлбөрт элсэгч 20,000 төг/ байна. Хураамжийг банкин дахь сургуулийн данс болон санхүүд бэлнээр тушааж болно. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

Дөрөв. СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТЭТГЭЛЭГ, ХӨНГӨЛӨЛТ

- 4.1. НССДС-д элсэгч нь ЭШ өгсөн амжилтаараа эхний нэг жил сургалтын төлбөрийн дараах хөнгөлөлт здлэх эрхтэй.

| ЭШ-ын оноо | Хөнгөлөлтийн хэмжээ |
|------------|---------------------|
| 600-650 | 20%-ийн хөнгөлөлт |
| 651-700 | 40%-ийн хөнгөлөлт |
| 701-750 | 60%-ийн хөнгөлөлт |
| 751-800 | 100%-ийн хөнгөлөлт |

- 4.2. НССДС-ийн Шилдэг элсэгч нь эхний нэг жил сургалтын төлбөрийн дараах хөнгөлөлт, дэмжлэгийг здлэх эрхтэй.

| Шалгуур үзүүлэлт | Хөнгөлөлтийн хэмжээ |
|--|-----------------------|
| Зуданд нэрвэгдсэний улмаас өрхийн амьжиргааны доогуур түвшинд бүртгэгдсэн малчны хүүхэд | 50-70 %-ийн хөнгөлөлт |
| Аймаг, дүүргийн хэмжээнд олимпиад, урлаг, спортын уралдаан, тэмцээнд 1-3-р байрт шалгарсан амжилт үзүүлсэн | 30%-ийн хөнгөлөлт |

| | |
|---|-------------------|
| Улсын хэмжээнд олимпиад, урлаг, спортын уралдаан, тэмцээнд 1-3-р байрт шалгарсан амжилт үзүүлсэн | 50%-ийн хөнгөлөлт |
| Олон улсын хэмжээнд олимпиад, урлаг, спортын уралдаан, тэмцээнд 1-3-р байрт шалгарсан амжилт үзүүлсэн | 70%-ийн хөнгөлөлт |

- 4.3. НССДС-ийн оюутан нь сургуулийн “Одтой оюутан” хөтөлбөрт хамрагдаж 5 одны болзол хангасан тохиолдолд сургалтын төлбөрийн 100%-тай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэлэгийг жил бүр олгоно.

Тав. ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1. Элсэлтийн комисс нь элсэлтийн үед баримтлах хэм хэмжээ, дэг журам, комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, явцын хяналт тавих, оюутан элсүүлэхтэй холбоотой маргаан, өргөдөл, гомдлыг тухай бүрт шийдвэрлэх зэрэг асуудлыг хариуцан ажиллана.
- 5.2. Элсэгч нь хяналтын тоонд багтсаны дараа өөрийн хүсэлтээр суралцахаас татгалзсан тохиолдолд сургалтын жилийн төлбөрийн 5 хувьтай тэнцэх төгрөгийг сургуулийн дансанд тушааж боловсролын бичиг баримтаа авна.
- 5.3. Тухайн жилийн элсэлтийн үйл ажиллагааны тайланг Элсэлтийн комисс бичгээр тайлагнана.

НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРГАА

- Хаяг: Улаанбаатар хот. Баянгол дүүрэг. 25-р хороо. Нарны зам 16/4. НССДС
- Вэбсайт: usp.mn
- Facebook хаяг: *Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль* <https://www.facebook.com/Universityofsociologyandpsychology>
-
- Бүртгүүлэх холбоос: usp.edu.mn/burtgel/
- Утас: 99098741, 9609-2222, 90089898, 11-362511

_____XXXX_____